



ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/232

Өмнөдэлгэр сум

Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.3, 19-20 дугаар зүйл, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Талбулаг багийн “Дунд сайхан” гэх газарт нутаглаж буй малчин Т.Баярсайханы суурьт Галзуу өвчин оношлогдож 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн хязгаарлалтын цээрийн дэглэм тогтоон, голомтод үзлэг, халдваргүйтгэл хийж ажилласны дүнд өвчин дахин илрээгүй тул хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Хязгаарлалтын дэглэмийг цуцалсантай холбогдуулан халдварт өвчний талаарх сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол хийж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (С.Гантоого), Талын булаг багийн Засаг дарга (М.Сод-Ирээдүй) нарт даалгасугай.

3. Эцсийн ариутгал халдваргүйтгэлийг чанартай зохион байгуулахыг “Хичээнгүй экспресс” мал эмнэлэгт, Галзуу өвчинтэй тэмцэх арга хэмжээний нэгдсэн тайланг гаргаж холбогдох газарт хүргүүлэхийг Мал эмнэлгийн тасаг (С.Гантоого)-т тус тус үүрэг болгосугай.



Р.ЭНХТӨР

D:\disk\bichig hereg/ zahiramj